

ДЭЛХИЙН ЭДИЙН ЗАСГИЙН ЧУУЛГАН

2008 оны 1-р сарын 23-нд Швейцарийн Давос хотноо Дэлхийн эдийн засгийн чуулганы нээлт болов.

Чуулганы гол сэдэв нь дэлхийн санхүүгийн хямрал, хүнсний зах зээлийн үнийн өсөлт, улс орнуудын эдийн засагт төрийн хөрөнгө оруулалтын үүрэг өсөн нэмэгдэж байгаа зэрэг асуудал болж, чуулган 1-р сарын 27-ыг хүртэл үргэлжилж, чуулганд дэлхийн 88 орны 2500 орчим төлөөлөгч, түүний дотор 27 орны төр, засгийн газрын тэргүүн нар оролцож байв.

Дэлхийн эдийн засгийн чуулган “форум” бол олон улсын засгийн газрын бус байгууллага юм. 1971 онд Европын тэргүүлэх компаниудын 450 удирдагч Женевт цугларан уулзснаар Дэлхийн эдийн засгийн чуулганы түүх эхэлжээ. Тус байгууллага 1971-1986 онд “Европын менежментийн форум” хэмээн нэрлэгдэж байв.

Форумын эхний уулзалтуудаар өрсөлдөөнт тэмцэлд Өрнөд Европын байр суурийг бэхжүүлэх асуудлыг голлон хэлэлцэж байв.

Жилээс жилд сэдэв аажмаар өргөжиж, улс төр, эдийн засгийн асуудал, шинжлэх ухаан-техникийн ололтын үр дагавар, шинэ тулгар орнуудын өрийн асуудлыг оролцуулан хэлэлцэж, 1970-аад оны дунд үеэс Давост дэлхийн дахины нөлөө бүхий хүмүүсийг “засгийн газрын гишүүд, бизнесийн том төлөөлөгчид” урих болжээ. Ингээд дараачийн арван жилд чуулган тухайн жилийн нэг гол үйл явдлын статустай болсон байна.

Форум нь дэлхийн янз бүрийн орны нэг мянга гаруй томоохон пүүс, корпорациудын төлөөлөлтэй. Форумын үндэслэгч, халаагүй удирдагч нь ерөнхийлөгч Женевийн бизнес-удирдлагын их сургуулийн профессор Клаус Шваб юм. Байгуулгын төв байр Женевт байрлана. Дэлхийн эдийн засгийн чуулган сар тутам гардаг өөрийн гэсэн хэвлэл “Уорлд линг” хэмээх сэтгүүлтэй.

Дэлхийн эдийн засгийн чуулганы гол арга хэмжээ нь 1-р сарын эцэс, 2-р сарын эхээр дэлхийд алдартай Давосын уулын цанын амралт сувиллын газарт жил бүр уламжлал ёсоор зохиогддог уулзалт юм.

2001 оны 9-р сарын 11-ний террорист халлагын дараа АНУ-тай эв санаа нэгтэй байгаагаа илэрхийлж 2002 онд Нью-Йоркт чуулсан юм.

Дэлхийд алдартай амралт сувиллын газарт жил бүр болдог уулзалтыг улс төр, эдийн засгийн нэн чухал асуудлуудыг албан ёсны бус байдалд хэлэлцэх зорилгоор зохион байгуулдаг. Давост болсон санал шүүмжлэл тухайн жилийн эдийн засгийн шийдүүштэй асуудлуудыг уламжлал ёсоор олон талаар тодорхойлдог. Маш олон янзын сэдвээр

семинар хийх нь Дэлхийн эдийн засгийн чуулганы ажлын үндсэн хэлбэр байдаг байна.

1979 оноос Дэлхийн эдийн засгийн чуулганы мэргэлжилтнүүд “Дэлхийн дахины өрсөлдөх чадвар” гэдэг жил бүрийн илтгэл бэлтгэж байна. Түүнд дэлхийн 100 гаруй оронд бодитой байж болох өсөлтийн индекс, өрсөлдөх чадварын индекс гэсэн хоёр гол үзүүлэлтээр үнэлэлт дүгнэлт өгдөг байна. Сүүлийн үед Дэлхийн эдийн засгийн чуулган тухайлсан бүс нутгууд, эдийн засгийн секторуудын чансааг тодорхойлдог болжээ.

Давосын зөвлөлгөөнөөс гадна Төв болон Дорнод Европ, Зүүн Өмнөд Ази, Ойрхи Дорнод, Хойд Африкийн асуудлаар дэлхийн эдийн засгийн чуулганы бүс нутгийн дээд хэмжээний уулзалтуудыг зохион байгуулжээ.

*Мэдээ бэлтгэсэн Г.Онон (ОУСХ-ийн
эрдэм шинжилгээний ажилтан)*